



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 3 сарын 27 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг  
томилж, удирдамж батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга Цэрэннадмидын Шинэхүүг томилсугай.

2. “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч Цэрэннадмидын Шинэхүүд даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013900

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын даргын 2024 оны 3 сарын 27-ны  
өдрийн 4/12 дугаартай тушаалын хавсралт

**“ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛД ТӨРИЙН ӨМЧИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН  
БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон энэхүү удирдамжийг баримтална:

1. Ногдол ашиг хуваарилахгүй талаар гарсан шийдвэр нь Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас гарсан тогтоол, шийдвэрүүдтэй нийцэж буй эсэхэд үнэлэлт өгч, Компанийн санхүүгийн болон нийгмийн өгөөжийн үзүүлэлтийг сайжруулах талаарх үүрэг чиглэлийг Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад өгөх;

2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцан, тус асуудалтай холбогдуулан гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд үнэлэлт өгч батлан, цаашид Компанийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулахад чиглэсэн байдлаар саналаа өгч оролцох;

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг чиглэл өгөх;

4. Засгийн газрын 2023 оны 84-р тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 7 дугаар зүйл болон бусад холбогдох заалтуудыг баримтлан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн хэмжээг тогтоох асуудалд санал өгч оролцох;

5. Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрмийн холбогдох зүйл заалтыг баримтлан “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудалд санал өгч оролцох;

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны зардлын төсөвтэй танилцан, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, саналаа тусгаж оролцох;